



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Өмч хамгаалах байнгын зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллах өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Хууль хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын мэргэжилтэн

Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

2. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тайлагнан, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зөвлөлийн дарга /Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2021 оны А/09 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  С.ХУЛАН

0823050008 3431274 НД1610

488412019